



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 15 өдөр

Дугаар 1/294

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Онцгой байдлын байгууллагын инновацын дунд хугацааны стратеги төлөвлөгөөний 2.3. дахь зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний 2-т "Онцгой байдлын байгууллагад бүтээмжийг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх" гэж заасныг хэрэгжүүлэхийн тулд Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, Инновацийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3, Гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөрийн 3.1.7-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ.

1. "Онцгой байдлын байгууллагын бүтээмжийн хөтөлбөр"-ийг хавсралтаар баталсугай.

2. Онцгой байдлын байгууллагын бүтээмжийн хөтөлбөрийг үйл ажиллагаандаа тусгаж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

3. Онцгой байдлын ерөнхий газрын даргын нэрэмжит жилийн эцсийн шалгалтын дүнд Онцгой байдлын байгууллагын бүтээмжийн хөтөлбөрийн хэрэгжилтийг ажлын үзүүлэлтэд тооцохыг Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын газар (хурандаа Г.Бат-Эрдэнэ)-т даалгасугай.

4. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дэд дарга (хурандаа Ц.Ганзориг)-д үүрэг болгосугай.

ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН

000029-7

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2020 оны 1-дугаар сарын 15-ны өдрийн
1/2020 дүгээр тушаалын хавсралт



ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЭМЖИЙН ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны А/334 дүгээр тушаалаар батлагдсан Онцгой байдлын байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөөний 2.3-т заасан "Алба хаагчдын инновацын мэдлэгийг сайжруулах, тэдгээрийг шинэ, шинэлэг санаа, арга зам дэвшүүлж үйл ажиллагаанд нэвтрүүлэхийг дэмжих" зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний 2-т "Онцгой байдлын байгууллагад бүтээмжийг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх" гэж заасан. Мөн Онцгой байдлын байгууллага 2020 онд дэвшүүлсэн "Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дэвшилтэт технологи, инновац, стандартыг нэвтрүүлэх" зорилтын хүрээнд батлагдсан Онцгой байдлын байгууллагын инновацын үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөөний 1-д Онцгой байдлын байгууллагын бүтээмжийн хөтөлбөрийг боловсруулж батлуулахаар тусгасан.

Хөтөлбөрийг Онцгой байдлын байгууллагын нийт алба хаагч, ажилтнуудыг хамруулан хэрэгжүүлнэ.

Хөтөлбөр нь тасралтгүй сайжруулах, нийт алба хаагч, ажилтнуудын оролцоог бүрэн хангах зарчимд тулгуурлана.

Хоёр. Зорилго

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь Онцгой байдлын байгууллагын алба хаагч, ажилтнуудын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, инновацын мэдлэгийг сайжруулах, тэдгээрийг шинэ, шинэлэг санаа, дэвшилтэт арга, шийдлийг дэвшүүлж үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийг дэмжих орчныг бүрдүүлж, байгууллагын ажлын бүтээмжийг дээшлүүлэхэд оршино.

Гурав. Зорилт

3.1. Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхэд дараах зорилтуудыг тавьж ажиллана. Үүнд:

3.1.1. Онцгой байдлын байгууллагын бүтээмжийг дээшлүүлэх орчин, нөхцлийг бүрдүүлэх;

3.1.2. Онцгой байдлын байгууллагын алба хаагч, ажилтнуудын бүтээлч хандлагыг төлөвшүүлэх замаар байгууллагын чанарын удирдлагад тасралтгүй сайжруулалтыг хэвшүүлэх;

3.1.3. Сайн саналын системээр дамжуулан инновацын дотоод эх үүсвэрийг бий болгох.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагаа

Хөтөлбөрийг 3 үе шатлалаар, 5 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ. Үүнд:

1 дүгээр үе шат 2021-2022 он, Онцгой байдлын байгууллагын бүтээмжийг дээшлүүлэх орчин бүрдүүлэх, алба хаагч, ажилтнуудын мэдлэг ур чадварыг сайжруулах;

2 дугаар үе шат 2022-2023 он, Онцгой байдлын байгууллагын алба хаагч, ажилтнуудын бүтээлч хандлагыг төлөвшүүлж, байгууллагын чанарын удирдлагад тасралтгүй сайжруулалтыг хэвшүүлэх;

3 дугаар үе шат 2023-2025 он, Сайн саналын системийг инновацын шинэ санааны эх үүсвэр болгох, инновацын төслүүдийг боловсруулах.

4.1. Онцгой байдлын байгууллагын бүтээмжийг дээшлүүлэх орчин бүрдүүлэх, алба хаагч, ажилтнуудын мэдлэг ур чадварыг сайжруулах (2021-2022 он) хүрээнд:

4.1.1. Нийт алба хаагч, ажилтнуудын дунд хөтөлбөрийг зарлан эхлүүлэх;

4.1.2. Алба хаагч, ажилтнуудын дунд хөтөлбөрийг хэрэгжүүлэх мэдлэг, чадвар олгох сургалт зохион байгуулах;

4.1.3. Бүтээмжийн хөтөлбөрийг зохион байгуулалтын 3 түвшинд хэрэгжүүлэх ба зөвлөл, бүлгийг байгуулах, тэдгээрийн ажиллах журмыг батлах;

4.1.4. Бүтээмжийн зөвлөл нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж батлуулан хэрэгжүүлэх;

4.1.5. Онцгой байдлын байгууллагын бүтээмж дээшлүүлэх гарын авлагыг боловсруулах;

4.1.6. Бүтээмжийн үнэлгээний тодорхой шалгуур бүхий үнэлгээний заавар боловсруулж батлуулах.

4.2. Онцгой байдлын байгууллагын алба хаагч, ажилтнуудын бүтээлч хандлагыг төлөвшүүлж, байгууллагын чанарын удирдлагад тасралтгүй сайжруулалтыг хэвшүүлэх (2022-2023) хүрээнд:

4.2.1. Онцгой байдлын байгууллагын бүтээмж дээшлүүлэх нөөцийг тодорхойлох;

4.2.2. Бүтээмжийн үндэс болох ажлын байрны аюулгүй байдал, эмх цэгцийг сайжруулах “5 сайн зарчим (5С)”-ыг алба хаагч, ажилтан бүр хэрэгжүүлэх;

4.2.3. Алба хаагч, ажилтнуудын бүтээлч хандлагыг төлөвшүүлэх “Сайн саналын систем (3С)”-ийг хэрэгжүүлэх;

4.2.4. Бүтээмжийн Зөвлөл, бүлгүүдийн харилцан туршлага солилцох, мэдээлэл цуглуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх нэгдсэн системийг үүсгэх.

4.3. Сайн саналын системийг инновацын шинэ санааны эх үүсвэр болгох, инновацын төслүүдийг боловсруулах (2023-2025) хүрээнд:

4.3.1. Алба хаагч, ажилтнуудын инновацын төсөл боловсруулах арга зүйд сургаж дадлагажуулах;

4.3.2. Инновацын төслүүдийг боловсруулах.

Тав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

5.1. Хөтөлбөрийг зохион байгуулалтын 3 түвшинд хэрэгжүүлнэ.

5.1.1. Онцгой байдлын ерөнхий газрын түвшинд: Хөтөлбөрийн удирдах зөвлөл

5.1.2. Төв, орон нутгийн онцгой байдлын байгууллага, харьяа салбаруудын түвшинд: Бүтээмжийн зөвлөл

5.1.3. Бүтцийн нэгжийн түвшинд: Бүтээмж, чанарын бүлгүүд.

5.2. Хөтөлбөрийн 4.1.3-т заасан зөвлөл, бүлгүүд нь дараах үндсэн чиг


үүрэгтэй ажиллана.

5.2.1. Хөтөлбөрийн удирдах зөвлөл нь Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар томилогдох ба бүтээмжийн зөвлөлийн үйл ажиллагаанд зөвлөх, удирдлагаар хангах, хяналт тавих, дэмжих, шаардлагатай санхүүгийн асуудлыг шийдвэрлэх, зарцуулалтад хяналт тавих, урамшуулах шийдвэр гаргах;

5.2.2. Бүтээмжийн зөвлөл нь бүтээмжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, тухайн салбар, нэгжийн онцлогт тохирсон бүтээмжийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хөтөлбөртэй холбоотой аливаа асуудлаар удирдах зөвлөлд мэдээлэл хийх, санал уламжлах;

5.2.3. Бүтээмж, чанарын бүлгүүд нь тухайн бүтцийн нэгжийн хэмжээнд бүтээмжийн хөтөлбөрийг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх, хувь хүний хандлага, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх.

5.3. “Бүтээмж, чанарын бүлгүүд” (БЧБ) нь салбар, нэгжүүд өөрсдийн хариуцсан ажлыг багийн зохион байгуулалттайгаар сайжруулж, харилцан өөрсдийгөө хөгжүүлэх замаар байгууллагын чанарын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож улмаар чанар, үр ашиг, бүтээмжийг сайжруулахад чиглэгдэнэ. БЧБ-ийн гишүүд үйл ажиллагаа явуулахад өөрт тулгамдаж байгаа асуудлыг ярилцаж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох ба үүний үр дунд алба хаагч, ажилтнууд шийдвэр гаргалтад нөлөөлснөөр тэдний ажилдаа хандах хандлага сайжирч бүтээмж нэмэгдэнэ. БЧБ-ээр байгууллагын дүрэм журам, хамтын гэрээ, өргөдөл гомдол, цалин, төсөв зэргийг хэлэлцэхгүй.




Бүдүүвч 1. Бүтээмжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх бүдүүвч

5.4. БЧБ-үүд нь 5 сайн зарчим (5С), Сайн саналын систем (3С) гэсэн 2 аргыг хэрэгжүүлж бүтээмжээ нэмэгдүүлэх ба эдгээр нь харилцан шүтэлцээтэй үйл ажиллагаа байна.

5.4.1. “5 сайн зарчим” (5С) нь хамгийн өндөр бүтээмжтэй хамт олон төдийгүй хамгийн бүтээмжтэй байгууллага болох анхны алхам юм. 5С-ийг хэрэгжүүлснээр ажлын байр, хөдөлмөр зохион байгуулалтыг боловсронгуй болгох стандарт журмыг тогтоон хэрэгжүүлэх, ажлын чанарыг сайжруулах, алба хаагч, ажилтнуудын хөдөлмөрийн сахилга батыг төлөвшүүлэхэд чиглэсэн системтэй үйл ажиллагааг бүрдүүлнэ. Өөрөөр хэлбэл ажлын байрны зохион байгуулалтыг

сайжруулах, ажлын төвөгшлийг багасгах, богино хугацаанд бага зардлаар илүү ихийг хийж гүйцэтгэх арга хэрэгслийн цогц юм.



Бүдүүвч 2. 5 сайн зарчим “5С” үйл ажиллагааны агуулга, үе шат

5С зарчимын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ дараах алхамуудыг баримтална. Үүнд:

1. Тасралтгүй сайжруулах 4 алхам (төлөвлөх → хийж гүйцэтгэх → үйл ажиллагаа ба үр дүнгээ хянах → үйл ажиллагаагаа хэвшүүлэх) – ыг баримтлах,

2. Сурсан зүйлээ хэвшүүлэх 4 алхам (сайжруулж байгаа үйл ажиллагаандаа стандарт тогтоох → стандартын дагуу хийж гүйцэтгэх → стандартын биелэлт, үр дүнд хяналт тавих → үйл ажиллагаагаа хэвшүүлэх) - ыг хэрэгжүүлэх,

5.4.2. “Сайн саналын систем (3С)” нь аливаа үйл ажиллагааг тасралтгүй алхам алхамаар сайжруулах чиг хандлага бөгөөд байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилготойгоор алба хаагч, ажилтнуудаас гарах шинэлэг санаа, бодлыг нэгтгэх зорилготой хийгдэнэ. Сайн саналын систем нь аливаа асуудлыг бүх нийтээр хамтран хэлэлцэж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох үндсэн дээр байгууллагын үйл ажиллагааг сайжруулж, үр ашиг, бүтээмж чанарыг дээшлүүлэх чиглэлээр алба хаагч, ажилтнуудаас гаргаж байгаа шинэ санал санаачлагыг урамшуулан дэмжих систем юм.



Бүдүүвч 3. “Сайн саналын систем 3С”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зохион байгуулалт

5.5 Онцгой байдлын байгууллагын сургалт, эрдэм шинжилгээ хариуцсан нэгжүүд, бусад мэргэжлийн хамтрагч байгууллага нь шинжлэх ухааны тусгай мэдлэгийн дэмжлэг үзүүлэх, туршилт хийх зэрэгт “Бүтээмжийн зөвлөл”-тэй хамтран ажиллана.

Зургаа. Үр дүн, шалгуур үзүүлэлт

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна. Үүнд:

6.1.1. Онцгой байдлын байгууллагын ажлын бүтээмж, чанар сайжрах нөхцөл бүрдэж, улмаар үйл ажиллагааны үр ашиг, үр дүн нэмэгдэж, алба хаагч, ажилтнуудын сэтгэл ханамж дээшлэн байгууллагын зорилго, зорилтын хэрэгжилт сайжирна.

6.1.2. Онцгой байдлын байгууллагад чанарын менежментийн тогтолцооны стандартыг хэрэгжүүлэх, хэвшүүлэх үндэс бүрдэнэ.

6.1.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд алба хаагч, ажилтан бүрийн оролцоо чухал тул нийт алба хаагч, ажилтнуудад “ажлын байрны нөхцлийг сайжруулах, тав тухтай орчинг бий болгох” гэдгийг ойлгуулах нь тэдэнд хөтөлбөрийг амжилттай хэрэгжих нөхцлийг бүрдүүлнэ. Үүний үр дүнд байгууллагын чиг үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлэх нөхцөл бүрдэж, урт хугацааны тогтвортой байдлыг хангах үндэс суурь бэхжих ач холбогдолтой.

6.2. Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр хэмжинэ.

6.2.1. Бүтээмжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын зөвлөл, бүлгүүд байгуулсан байх, тэдгээрийн ажиллах журам батлагдсан байх;

6.2.2. Онцгой байдлын байгууллагын бүтээмж дээшлүүлэх гарын авлагыг боловсруулсан байх;

6.2.3. Бүтээмжийн үнэлгээний тодорхой шалгуур бүхий үнэлгээний заавар боловсруулсан байх;

6.2.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх мэдлэг, чадвар олгох сургалтад алба хаагч, ажилтнууд хамрагдсан байх;

6.2.5. Онцгой байдлын байгууллагын бүтээмж дээшлүүлэх нөөц, боломжийг тодорхойлсон байх;

6.2.6. Бүтээмжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлагдаж хэрэгжсэн байх;

6.2.7. Бүтээмж дээшлүүлэх “5 сайн зарчим (5C)”, “Сайн саналын систем (3C)”-ийг хэрэгжүүлж, хэвшүүлсэн байх;

6.2.8. Сайн инновацын төслүүд боловсруулсан байх.

Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

7.1.1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;

7.1.2. орон нутгийн хөгжлийн сан;

7.1.3. иргэд, аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын болон иргэний нийгмийн байгууллагын хандив, тусламж;

7.1.4. Бусад

Найм. Хөтөлбөрийн үр дүн, хяналт шинжилгээ, үнэлгээ

8.1. Бүтээмжийн зөвлөл нь хагас жил тутам хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, үр дүнг хөтөлбөрийн Удирдах зөвлөлд танилцуулах бөгөөд хөтөлбөрийн удирдах зөвлөл нь урамшуулах, сайжруулалт хийх саналыг гаргана.

8.2. Бүтээмжийн хөтөлбөрийн гүйцэтгэлийг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны А/236 дугаар тушаалаар батлагдсан “ОББ-ын харьяа салбар

нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах аргачлал, заавар”, Бүтээмжийн үнэлгээний тодорхой шалгуур бүхий стандарт болон үнэлгээний журмын дагуу үнэлнэ.

---o0o---